



АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН ЯАМ
АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР
ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН
ЗӨВЛӨЛИЙН ДҮГНЭЛТ

2025 оны 12 сарын 04 өдөр

Дугаар ТЦА-2025-02-03

Улаанбаатар хот

Газрын тос, уламжлалт бус газрын
тосны хайгуулын талбайг бүхэлд
болон хэсэгчлэн нь буцаан авах
тухай

Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2025 оны 10 дугаар сарын 01-ны өдрийн А/211 дугаар тушаалаар шинэчлэн батлагдсан “Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын талбайг буцаан өгөх, хүлээн авах журам”-ын 3.6 дахь хэсгийг үндэслэн Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн Газрын тосны асуудал хэлэлцэх салбар зөвлөлийн 2025 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдаанаар

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

1. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд /хуучин нэрээр/, Байгаль орчин аялал, жуулчлалын сайд /хуучин нэрээр/ нарын 2021 оны А/62, А/233 дугаар хамтарсан тушаалаар байгуулагдсан “Уламжлалт бус газрын тосны хайгуулын Онги V, Богд IV, Т1 талбайгаас хэсэгчлэн, газрын тосны хайгуулын Онги V талбайг бүхэлд нь буцаахад дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн нэгдсэн санал дүгнэлт,
2. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд /хуучин нэрээр/, Байгаль орчин аялал, жуулчлалын сайдын /хуучин нэрээр/ 2021 оны А/253, А/309 дүгээр хамтарсан тушаалаар байгуулагдсан Газрын тосны хайгуулын Матад-ХХ талбайг хэсэгчлэн буцаахад дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн нэгдсэн санал дүгнэлт,
3. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд /хуучин нэрээр/, Байгаль орчин аялал, жуулчлалын сайдын /хуучин нэрээр/ 2023 оны А/244, А/244 дүгээр хамтарсан тушаалаар байгуулагдсан Уламжлалт бус газрын тосны хайгуулын Номгон-IX талбайг хэсэгчлэн буцаах тухай дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн нэгдсэн санал дүгнэлт,
4. Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд /хуучин нэрээр/, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын /хуучин нэрээр/ 2024 оны А/15, А/704 дүгээр хамтарсан тушаалаар байгуулагдсан Уламжлалт бус газрын тосны хайгуулын Гурвантэс ХХХV талбайг хэсэгчлэн буцаах тухай дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн нэгдсэн санал дүгнэлт,
5. Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд /хуучин нэрээр/, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын /хуучин нэрээр/ 2024 оны А/45, А/812 дугаар хамтарсан тушаалаар байгуулагдсан Уламжлалт бус газрын тосны хайгуулын Тавантолгой ХХХIII талбайг хэсэгчлэн буцаах тухай дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн нэгдсэн санал дүгнэлт,
6. Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд /хуучин нэрээр/, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын /хуучин нэрээр/ 2024 оны А/126, А/470 дугаар

1535801210

хамтарсан тушаалаар байгуулагдсан Газрын тосны хайгуулын Төхөм Х урд талбайн зарим хэсгийг бүхэлд нь болон хэсэгчлэн буцаах тухай дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн нэгдсэн санал дүгнэлт,

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Гэрээлэгчийн Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу уламжлалт бус газрын тосны хайгуулын Онги V, Богд IV, Т1, Номгон-IX, Гурвантэс XXXV, Тавантолгой XXXIII талбай; газрын тосны хайгуулын Онги V, Матад-XX, Төхөм Х урд талбайд хийж гүйцэтгэсэн хайгуул, судалгааны ажлын хэмжээ, хөрөнгө оруулалт болон байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх үүргийн биелэлт нь хууль, тогтоомжид заасан шаардлагыг хангаж байх талаарх ажлын хэсгүүдийн дүгнэлт, зөвлөлийн гишүүдийн санал, “Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн дүрэм”-ийн 1.2, 3.2.6, 5.6.1 дахь хэсэг, “Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын талбайг буцаан өгөх, хүлээн авах журам”-ын 3.6 дахь хэсгийг тус тус үндэслэн дараах шийдвэрийг гаргав.Үүнд:

1. Уламжлалт бус газрын тосны хайгуулын Богд IV талбайгаас 3,194 км² талбайг хэсэгчлэн буцаан авахаар, уламжлалт бус газрын тосны хайгуулын Т1 талбайгаас 1,201 км² талбайг хэсэгчлэн, уламжлалт бус газрын тосны хайгуулын Номгон-IX талбайгаас 5,634 км² талбайг хэсэгчлэн, уламжлалт бус газрын тосны хайгуулын Онги V талбайгаас 2,286 км² талбайг хэсэгчлэн, уламжлалт бус газрын тосны хайгуулын Гурвантэс XXXV талбайгаас 443.1 км² талбайг хэсэгчлэн, уламжлалт бус газрын тосны хайгуулын Тавантолгой XXXIII талбайгаас 35 км² талбайг хэсэгчлэн, газрын тосны хайгуулын Матад-XX талбайгаас 10,148.54 км² талбайг хэсэгчлэн, газрын тосны хайгуулын Төхөм Х урд талбайгаас 7,823.53 км² талбайг хэсэгчлэн, газрын тосны хайгуулын Онги V талбайг бүхэлд нь буюу 7,936.95 км² талбайг тус тус буцаан авахаар шийдвэрлэв.
2. Дээрх газрын тосны хайгуулын талбайнуудаас хэсэгчлэн буцаан авсантай холбогдуулан тус талбайнуудын үлдсэн хэсэгт явуулах уламжлалт болон уламжлалт бус газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа болон бүтээгдэхүүн хуваах гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах, газрын тосны хайгуулын Онги V талбайг бүхэлд буцаан авсантай холбогдуулан гэрээг дүгнэх ажлыг зохион байгуулахыг Аж үйлдвэр, эрдэс баялагийн яамны Газрын тосны бодлогын газар /Ч.Хишигдалай/, Ашигт малтмал, газрын тосны газар /П.Баянбаатар/-т тус тус үүрэг болгов.

ТАНИЛЦСАН:

ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

ХЯНАСАН:

ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН
ЗӨВЛӨЛИЙН ГАЗРЫН ТОСНЫ АСУУДАЛ
ХЭЛЭЛЦЭХ САЛБАР ХУРАЛДААНЫ ДАРГА

БОЛОВСРУУЛСАН:

ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН
ЗӨВЛӨЛИЙН ГАЗРЫН ТОСНЫ АСУУДАЛ
ХЭЛЭЛЦЭХ САЛБАР ХУРАЛДААНЫ
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Б.ДАШПҮРЭВ

Ч.ХИШИГДАЛАЙ

П.ОЮУНТУЯА